

**Монгол хэлний “өөрөөр хэлбэл” гэдэг холбох  
үгийн бүтэц, утга, үүрэг, хэрэглээ**

**Б.Пүрэв-Очир (МУБИС)**

Бид орчин цагийн монгол хэлний “ба, хоёр, эсвэл, аль эсвэл, нэг бол, бөгөөд, агаад, хийгээд, болон, харин, гэвч, байтугай, тэр ч байтугай, мөн, мөнхүү, бас басхүү, болбол, бол, хэрэв... бол, хэрэв... зээ, ялангуяа, буюу, ...” гэх зэрэг зэрэгцүүлэн холбох үгс болон зарим гадаад холбох хэрэглүүрийн бүтэц, үгзүйн, өгүүлбэрзүйн шинж, онцлог, харьцааны утга, үүрэг, хэрэглээний талаар төрөл бүрийн найруулгын баримтад тулгуурлан, тусгайлсан судалгаа хийж, цөөнгүй ажил хэвлүүлсэн билээ<sup>1</sup>. Эдгээр судалгаа нь монгол хэлний өгүүлбэрээс доошхи ба дээшхи нэгжүүдийг холбодог зэрэгцүүлсэн ба угсруулсан, дотоод ба гадаад, нийлэг ба задлаг, бэхэжсэн (ил) ба бэхжээгүй (далд), үүсмэл ба үүсмэл бус, дан ба давхар, нийлүүлдэг ба салгадаг, зогсонги ба хөдлөнг, утгыг нэгтгэх ба эсрэгцүүлдэг холбох хэрэглүүрийг бүхий тогтолцоогоор нь үгзүй, өгүүлбэрзүй, утгазүй, хэрэглээний хэлзүйн талаас нь цогцолбор судлахад чиглэгдсээр байгааг юуны өмнө тэмдэглэе. Ер, монгол хэлэн дэх холбох үгсийн “**өгүүлбэрзүйн судалгаа**” харьцангуй хоцорч байсныг бид анхаарч, өгүүлбэрзүй, утгазүйн судалгааны нэгэн чухал судлагдахуун мөн гэж үзэж, дэс дараатайгаар бүртгэн, хэлбэр ба утгаас нь судлах оролдлогыг хийсээр байгаа болно.

1. Өгүүлбэр болон эхийн найруулгад үлэмж чухал үүрэгтэй “**дотоод ба гадаад холбох үгс**” гэж нэрлэгддэг бүлэг үгсийг үгзүйн шинж, өгүүлбэрзүйн үүрэг, илэрхийлэх утга, найруулга, хэрэглээний талаас нь ажиглаад, ерөнхий зүй тогтлынх нь талаар дараах тоймыг хийж болох юм.

Үүнд:

- а. “**ба, хоёр**” нь утга, үүргээрээ төсөөтэй, нэгий нь нөгөөгөөр нь солин найруулах боломжтой, хэрэглээ нь ойролцоо шинжтэй, жишээ нь: чоно ба хурга, чоно, хурга хоёр г.м.
- б. “**эсвэл, аль эсвэл, нэг бол, эсхүл**” нь үүрэг, утгаараа төсөөтэй, нэгий нь нөгөөгөөр нь солин найруулах боломжтой, хэрэглээ нь ойролцоо байна.

<sup>1</sup> Б.Пүрэв-Очир, Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй, тэргүүн дэвтэр, нэмсэн II хэвлэл, УБ., 2001; Б.Пүрэв-Очир, Монгол хэлний өгүүлбэрзүй, Утгасудлалын асуудлууд, дэд дэвтэр, нэмсэн II хэвлэл, УБ., 2000; Б.Пүрэв-Очир, Монгол хэлний дадлагын өгүүлбэрзүй, (агуулга, аргазүй, дидактикийн асуудлууд), гутгаар дэвтэр, нэмсэн III хэвлэл, УБ., 2003; Б.Пүрэв-Очир, Монгол хэлний “бол” холбоост нийлмэл өгүүлбэр, “Сурган хүмүүжүүлэгч” сэт., УБ., 1990, №3, 44-46-р тал; Б.Пүрэв-Очир, Монгол хэлний “буюу” гэдэг холбох үгийн өгүүлбэрзүй-найруулгын үүрэг, “Шинжлэх ухааны Академийн мэдээ” сэт., УБ., 1993, №1, 13-17-р тал; Б.Пүрэв-Очир, Монгол хэлний “харин” гэдэг холбох үгийн утга, үүрэг, найруулгад хийсэн зарим ажиглалт, Монголч эрдэмтний VI их хуралд зориулсан “Монгол хэлшинжлэл” цуврал, №1, (23), 6-р дэвтэр, УБ., 1992, 45-50-р тал; Б.Пүрэв-Очир, Монгол хэлний зарим холбох үгийн утга, үүрэг, найруулгад хийсэн ажиглалт, Олон улсын монгол судлалын холбооны “MONGOLICA” цуврал, УБ., 1993, №4 (25), 55-74-р тал.

- в. “**ба, бөгөөд, агаад, хийгээд, болон**” эдгээр нь үүрэг, утга, хэлбэрээрээ төсөөтэй, нэгий нь нөгөөгөөр нь солин найруулах боломжтой, хэрэглээ нь ойролцоо шинжтэй.
- г. “**харин, гэвч**” хоёр нь үүрэг, утгаараа төсөөтэй, нэгий нь нөгөөгөөр нь солин найруулах боломжтой, хэрэглээ нь ойролцоо шинжтэй байна.
- д. “**байтугай, тэр ч байтугай, төдийгүй, бүү хэл, битгий хэл ...**” эдгээр нь үүрэг, утгаараа төсөөтэй, нэгий нь нөгөөгөөр нь солин найруулах боломжтой, хэрэглээ нь бичгийн ба ярианы хэлэнд ойролцоо шинжтэй болно.
- е. Монгол хэлэнд “**болбол, бол ...**” хэмээх холбох үгс нь захируулах (угсруулах) ба зэрэгцүүлэх холбоонд хоёуланд нь хоёр өөр утга, үүрэгтэйгээр хэрэглэгддэг. Тухайлбал, “Иргэн нь баян **болбол (бол)** улс нь баян байдаг” гэсэн өгүүлбэрт “**болбол (бол)**” нь захируулах холбоон дээр нөхцөл болзлын утгатай, захируулах холбооны үүрэгтэйгээр хэрэглэгдсэн байхад, “Найз минь, онол бор саарал **байдаг бол** амьдралын мод мөнх ногоон байдаг.” (Мефистофель) гэсэн өгүүлбэрт “**бол**” холбоос нь хоёр өгүүлбэрийн утгыг эсрэгцүүлэн жишээд сөргүүлэн тавих утгатай зэрэгцүүлэн холбох үгийн үүрэгтэйгээр хэрэглэгдсэн байна. Энэ нь монгол хэлний зарим холбох үгс нь утга, үүргээрээ ондоошиж бас зарим нь эсрэгцэж хөгжсөнийг харуулж буй баримт даруй мөн.
- ё. Бидний ажигласнаар, “**хэрэв ... бол, хэрэв ... зээ**” гэсэн холбох үгс нь үүрэг, утгаараа төсөөтэй, нэгий нь нөгөөгөөр нь орлуулан найруулах боломжтой боловч нэг нь бичгийн хэлний өгүүлбэрзүйд голлон хэрэглэгддэг, нөгөө нь ярианы хэлний өгүүлбэрзүйд идэвхтэй хэрэглэгдэгээрээ ялгаатай юм. Харин илэрхийлэх утгын тал нь ойролцоо шинжтэй байна.
- ж. Монгол хэлний “**буюу**” холбоос нь “**өөрөөр хэлбэл**”-тэй утга ба үүргээрээ тун ойролцоо нь ажиглагддаг. Өөрөөр хэлбэл, “**буюу**”-г зарим тохиолдолд “**өөрөөр хэлбэл**”-ээр солин найруулах боломжтой байдаг. Үүнийг доор жагсаасан жишээнүүдээр баталж болно.

Үүнд:

- Наран саран тамга **буюу (өөрөөр хэлбэл)** жинстэй саран тамга... (Л.Түдэв),
- Усны эргүүлэг **буюу (өөрөөр хэлбэл)** борзооны явдал... (П.Лувсанцэрэн),
- “Дайду” **буюу (өөрөөр хэлбэл)** Их нийслэл... (З.Мөнхдалай),
- Судрын зургаа дахь хуудасны үргэжлэл **буюу (өөрөөр хэлбэл)** цагаан лавай хэмээх белег... (Г.Мэнд-Ооёо),
- $2 \times 2 = 6$ , **буюу** суут жаран сэтгэгч... (Г.Аюурзана),
- “ГУНУ” урсгал **буюу (өөрөөр хэлбэл)** “Гол ус намуухан урсна.” хэмээх уран зохиолын урсгал... (Д.Галбаатар),
- Элегия **буюу (өөрөөр хэлбэл)** гунигт шүлэг (Ш.Сүрэнжав),
- Дао **буюу (өөрөөр хэлбэл)** Зам хэмээх нэр томъёо нь байгалийн жам хуультай нарийн холбоотой... (Г.Аюурзана),
- Дорнын шөнийн нууц **буюу (өөрөөр хэлбэл)** хатдын удвис... (Ш.Сүрэнжав),
- Хуучнаар Сайн ноён хан аймгийн Эрдэнэ засаг Жамьян вангийн хошуу **буюу (өөрөөр хэлбэл)** одоогийн Баянхонгор аймгийн Заг сум... Н.Түмэнжаргал) г.м.

Дээр дурдсан баримт жишээнээс харахад, орчин цагийн монгол хэлний “**буюу**” хэмээх холбох үгийн утга, үүрэг, хэрэглээг хэл, хэлэхүйн харьцаанд нарийвчлан судалъя гэвэл “**өөрөөр хэлбэл**”-ийг судлах, “**өөрөөр хэлбэл**”-ийг тусгайлан судалъя гэвэл өгүүлбэрийн онцолбор гишүүн хийгээд тодосгогч-тодосгуулагчийн харьцаа холбоо бүхий давхар гишүүн, ялангуяа түүний холбоост хэв маягууд, “**буюу**” хэмээх холбох үгийн утга, үүрэг, хэрэглээ зэрэгтэй нягт шүтэлцүүлэн судлах шаардлагатай байгаа нь тодорхой болж байна.

2. Энэхүү судалгаанд бид орчин цагийн монгол хэлний “**буюу**”-гийн өгүүлбэрзүйн утга, үүрэг, хэрэглээний талаар дахин дэлгэрүүлэн авч үзэх зорилго тавиагүй. Учир нь нь өмнө бид “**буюу**”, улмаар холбоосгүй ба холбоост тодосгогч гишүүний талаар зарим судалгааг хийж хэвлүүлсэн юм<sup>2</sup>. Харин монгол хэлний “**өөрөөр хэлбэл**” гэдэг холбох үгийн бүтэц, утга,

<sup>2</sup> Б.Пүрэв-Очир, Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй, тэргүүн дэвтэр, нэмсэн II хэвлэл, УБ., 2001; Б.Пүрэв-Очир, Монгол хэлний дадлагын өгүүлбэрзүй, (агуулга, аргазүй, дидактикийн асуудлууд), гутгаар дэвтэр,

үүрэг бусад холбох үгээсээ ялгарах онцлог, хэрэглээний тухай асуудлыг бага боловч тодруулан судлах зорилго тавьж байна.

3. Дээр холбогдуулж өгүүлснээс бодвоос, монгол хэлний “**буюу**” гэдэг холбох үгээр зэрэгцсэн харьцаа холбоо, зэрэгцсэн гишүүний хэлхэцийг төдий л үзүүлдэггүй, харин гагцхүү тодосгогч-тодосгуулагчийн холбоо харьцаа бүхий давхар тодосгогч бүхий онцолборыг хэлэхүйн цуваанд илрүүлдэг нь гол шинж гэж үзэх үндэстэй байна. Ингээд монгол хэлний холбоост тодосгогчийг илрүүлдэг “**буюу**”-гаас өөр холбох үг байна уу, ямар холбох үгс байгаа, ямар онцлогтой? зэргийг тусгайлан судалбал сонин зүйл гарч болно.

Энд монгол хэлний “**өөрөөр хэлбэл**” гэсэн нийлмэл бүтэцтэй холбох үг сонирхол татаж байна. “**Өөрөөр хэлбэл**”-ийг бараг хүн бүр аман ба бичгийн хэлний найруулгад хэрэглэдэг боловч, яагаад хэрэглэдэг, ямар утга, үүргээр холбодог, “**өөрөөр хэлбэл**” нь ямар ямар хувилбартай болох, “**Буюу**”-гаас ялгарах шинж, түүний хэрэглээний онцлог, өгүүлбэр холбох, өгүүлбэрээс дээшхи нэгжийг холбоход ямар учир холбогдолтой зэргийг нь төдий л сонирхон судалсангүй иржээ. Иймээс “**өөрөөр хэлбэл**” нь монгол хэлний холбох хэрэглүүрийн дотроос бараг судлагдаагүй шахам байгаа холбох үг юм гэж үзэж байна. Энэ нь холбоост тодосгогч гишүүнтэй нягт шүтэлцээтэй, холбох үгсийн өгүүлбэрзүйд хамаатай юм.

Доктор, проф. Ц.Өнөрбаян “**өөрөөр хэлбэл**”-ийг өгүүлбэрийг холбох үгэнд оруулж, нэг эсвэл хэд хэдэн өгүүлбэрийг холбодог<sup>3</sup> гэсэн байхад, доктор, проф. Д.Отгонсүрэн “Өгүүлбэрийн эхэн ба адагт тохиолдохгүй, гагцхүү өгүүлбэрүүдийн дунд тохиолдох тодорхой байртай. Тэгээд, “**өөрөөр хэлбэл**”-ийг байрын талаас өмнөх, хойнох өгүүлбэртэй холбогдож, холбох үгийн үүрэгтэй, дундаас нь холбодог дотоод холбоос”<sup>4</sup> гэсэн санаагаар тайлбарласан байдаг.

Доктор Ю.Мөнх-Амгалан “**Баймж утга илтгэсэн оруулсан үг**<sup>5</sup> гэж үзсэн бол, акад.Ш.Лувсанвандан зэрэг эрдэмтэн, өгүүлбэрийн гишүүнд хэлзүйн холбогдолгүй үг<sup>6</sup> гэж үзсэн байх жишээтэй байна.

Проф. Т.А.Бертагаев “Союзы”<sup>7</sup> хэмээх судалгааны өгүүлэлдээ “**өөрөөр хэлбэл**”-ийн талаар тодорхой юм дурдаагүй билээ.

Бид монгол хэлний “**өөрөөр хэлбэл**” гэдэг нийлэмжийг үүсмэл, нийлмэл бүтэцтэй, гол нь тодосгогч-тодосгуулагч хоёрыг онцлох, тайлбарлах утгатай, “**ондоогоор хэлбэл**”, “**нэг үгээр хэлбэл**”, “**нөгөө үгээр хэлбэл**”, “**нөгөөгөөр хэлбэл**”, “**өөр утгаар хэлбэл**”, “**нөгөө утгаар хэлбэл**” г.м. солин найруулах боломжтой хэд хэдэн хувилбартай, оруулбар нэгжийн байдалтай хэрэглэгддэг, тайлбарлах утга бүхий “**холбох үг**” гэж үзэж байна.

Ер, монгол хэлний “**A<sub>1</sub> – буюу – A<sub>2</sub>**”, “**A<sub>1</sub> – өөрөөр хэлбэл – A<sub>2</sub>**” гэсэн загварт бүтэцтэй нийлэмжүүдийг ажиглавал, **A<sub>1</sub> ... A<sub>2</sub>** гэсэн хоёр бүрдүүлбэр нь адил тэнцүү чанартай мэдээллийг агуулсан, нэг нь нөгөөгөө тодосгон, нэг бол дэлгэрүүлж, эсвэл хурааж тайлбарлаж онцолсон шинжтэй, бас ерөнхийдөө ижил төстэй утга санааг илэрхийлсэн, хам бүтцийн талаасаа өөрчлөн хувиргаж хийсэн нэгэн өвөрмөц давталтын шинжтэй, бас нэг нь нөгөөгөө орлох үүрэгтэй тийм өвөрмөц онцлогийг хадгалдаг зүй тогтолтой байна гэж үзэв. Үүгээрээ “**өөрөөр хэлбэл**” нь бусад холбох үгээсээ өвөрмөц ялгаатай юм. Жишээ нь:

нэмсэн III хэвлэл, УБ., 2003; Б.Пүрэв-Очир, Монгол хэлний “буюу” гэдэг холбох үгийн өгүүлбэрзүй-найруулгын үүрэг, “Шинжлэх ухааны Академийн мэдээ” сэт., УБ., 1993, №1, 13-17-р тал; Б.Пүрэв-Очир, Монгол хэлний зарим холбох үгийн утга, үүрэг, найруулгад хийсэн ажиглалт, Олон улсын монгол судлалын холбооны “MONGOLICA” цуврал, УБ., 1993, №4 (25), 55-74-р тал.

<sup>3</sup> Ц.Өнөрбаян, Орчин цагийн монгол хэлний үгзүй, УБ., 1998. 225-р тал.

<sup>4</sup> Д.Отгонсүрэн, Монгол хэлний холбоос үгийн найруулгын үүрэг, товхимол, УБ., 1978. 74-р тал.

<sup>5</sup> Ю.Мөнх-Амгалан, Орчин цагийн монгол хэлний баймжийн ай, УБ., 1998. 129-р тал.

<sup>6</sup> Ш.Лувсанвандан, Монгол хэлний хэлзүйн сурах бичиг, Үгүүлбэрийн зүй, дэд дэвтэр, УБ., 1956; Ш.Лувсанвандан, Монгол хэлний үгүүлбэрзүйн асуудлууд, III боть, УБ., 2000, эмхтгэж өмнөтгөл хийсэн доктор Б.Пүрэв-Очир.

<sup>7</sup> Т.А.Бертагаев, Холбоос (Союзы), STUDIA MONGOLICA, Tomus-IV, Fasc. 1-7., УБ., 1968. др. А.Цог-Очирын орчуулга: МУБИС. Монгол судлалын сургууль, “Монгол хэлшинжлэл” цуврал (Эрдэм шинжилгээний сэтгүүл), №6, УБ., 2004, 205-236-р тал.

- а. Мянган онигоо (A<sub>1</sub>) **буюу** тайвшруулах эм... (A<sub>2</sub>).
- б. Мянган онигоо (A<sub>1</sub>) **өөрөөр хэлбэл**, тайвшруулах эм... (A<sub>2</sub>).
- а. Да багш (A<sub>1</sub>) **буюу** Дамдинсүрэн багш... (A<sub>2</sub>).
- б. Да багш (A<sub>1</sub>) **өөрөөр хэлбэл**, Дамдинсүрэн багш... (A<sub>2</sub>).

а. Парадокс – энэ нь герег хэлний paradoxos (A<sub>1</sub>) **буюу** санаандгүй, хачин гэдэг үгээс гаралтай ажээ. (A<sub>2</sub>)

б. Парадокс гэдэг нь герег хэлний paradoxos (A<sub>1</sub>) **өөрөөр хэлбэл**, санаандгүй, хачин гэдэг үгээс гаралтай ажээ. (A<sub>2</sub>) г.м.

Төрөл бүрийн найруулгын баримтаас ажиглахад, монгол хэлний өгүүлбэрээс доошхи ба дээшхи нэгжийн тогтолцоонд “**буюу**” хийгээд “**өөрөөр хэлбэл**”-ээр холбох зүй тогтол нь хэлбэржсэн үгээс – цогцолбор хүртэлх бага, их ангийн харьцаанд нэвт үйлчилдэг нь их сонин байна.

Өгүүлбэрзүйн нэгжүүдийн шаталсан харьцаанд, доод ба дээд түвшний нэгжүүдийн багц дээр үүнийг үзүүлбэл:

0. **Зэрэгцүүлэх ба оруулан зэрэгцүүлэх холбоо:** арга ба хэрэглүүр нь: “**буюу**”, “**өөрөөр хэлбэл**”,
1. **Хэлбэржсэн үгийн түвшинд:** Жишээ нь:
  - а. Лу багш **буюу** Лувсанвандан багш...
  - б. Лу багш **өөрөөр хэлбэл** Лувсанвандан багш...
2. **Холбоо үг буюу нийлэмж үгийн түвшинд:** Жишээ нь:
  - а. Шагжийн толь **буюу** хөх толь...
  - б. Шагжийн толь **өөрөөр хэлбэл** хөх толь...
3. **Энгийн өгүүлбэрийн түвшинд:** Жишээ нь:
  - а. Үг бүтэх явцын үр дүнд үгийн сангийн шинэ нэгж үүсэх **буюу** үг бүтэх ёс нь үг бүтээх үндсэн үүрэгтэй юм.
  - б. Үг бүтэхийн явцад үгийн сангийн шинэ нэгж үүсч бий болно. **Өөрөөр хэлбэл** үг бүтэх ёс нь шинэ үгийг бүтээх үндсэн үүрэгтэй байдаг.
4. **Нийлмэл өгүүлбэрийн түвшинд:** Жишээ нь:
  - а. Нарийн тогтолцоотой хэлний нэгжүүд нь нэг нь нөгөөтэйгөө эсрэгцэхийн зэрэгцээ бас бие биеэ нөхөж давхарлан шаталж байдаг. **Өөрөөр хэлбэл** дээд түвшний нэгж нь доод түвшнийхээ нэгжийг багтааж, бас бага анги нь их ангидаа залгамжлагдсан чанартай байдаг. (Б.Пүрэв-Очир)
5. **Цогцолборууд хийгээд эхийн түвшинд:** Жишээ нь:
 

Сүү, цагаан идээгээрээ төрөл бүрийн хүнс хоол бэлтгэхээр барахгүй сүүгээр архи нэрдэг эрдэм сурчээ. Зөвхөн сүм хийдэд шавилан суусан лам нар мацагладаг биш харин ч монгол хүн болгон зуны гурван сард зарим нь бүр зун, намрын зургаан сард мацаг барьдаг байлаа. **Өөрөөр хэлбэл** зун, намрын цагт гагцхүү цагаан идээгээр (сүү, тараг, ааруул, эзгий, өрөм, бяслаг, айраг, дарс) хооллож, өвлийн улиралд махан зууш хэрэглэж, тэр нь бичигдээгүй мөртлөө бүх нийтээр дагадаг хууль байсан билээ. (Л.Түдэв) г.м.

Дээр үзүүлсэн шаталсан тогтолцоот нэгжүүд хийгээд эрдэм шинжилгээний, сонин нийтлэлийн, ярианы, урансайхны (гол төлөв үргэлжилсэн үгийн хүүрнэмж, тайлбарламж, тоочимж, эргэцүүлэмж эхийн) найруулгын жишээ баримтаас судалж үзэхэд “**өөрөөр хэлбэл**”, “**буюу өөрөөр хэлбэл**” нь нэг талаар, дотоод холбох үгийн үүрэгтэйгээр төгс бус хоёр нэгжийг ч дундаас нь холбодог, нөгөө талаар, гадаад холбоосын үүрэгтэйгээр орж, төгс хоёр нэгжийг ч нөхцөлдүүлэн холбож, оруулан зэрэгцүүлдэг үндсэн зүй тогтолтой болох нь харагдаж байна.

Ингэхэд тодосгуулагч - тодосгогчийн харьцаа холбоо, үүрэг хамааралтай, төгс ба төгс бус нэгжүүдийг холбодог бөгөөд нэг ижил ухагдахуун, ойлголт, утга санаа, мэдээллийг хоёр удаа тайлбарлан, хувиргаж илэрхийлсэн онцлогтой байдаг ажээ. Тухайлбал, Наймдугаар Богд Жавзундамба хутагт, **буюу өөрөөр хэлбэл**, Халхын Өндөр Гэгээн Занабазар, Монгол хэлэнд ар, өвөр монголын олон нутгийн аялгуу, **буюу өөрөөр хэлбэл**, Халх, Цахар, Ордос, Хорчин, Харчин зэрэг олон аялгуу багтдаг г.м.

Хэлэх өгүүлэхүйн явцад тухайлбал, өгүүлэгч ба сонсогч бие нь ямар орон цагт, ямар зорилго, шалтгаанаар, ямар сэтгэл хөдлөл, эрмэлзэл, ямар үнэлэмжтэйгээр, ямар орчин нөхцөлд хэлийг ашиглаж мэдлэг бүтээдэг хийгээд улмаар дискурс буюу уялдаа яриаг хэрхэн бүтээх (representation), хэрхэн ойлгож тайлбарлах (interpretation), тэдгээрийг хэрхэн дараалж эрэмбэлэх (sequential) гэсэн гурван гол асуудалтай "**өөрөөр хэлбэл**" гэдэг холбох үгийн үүрэг, утга, хэрэглээ нь шүтэлцээтэй байна гэж үзэж байна.

Монгол хэлний найруулгын төрлүүдээс хүүрнэмж, тайлбарламж, тоочимж, эргэцүүлэмж эх болон цогцолборын найруулгад "**өөрөөр хэлбэл**"-ийг хэрэглэсэн онцлог, түүний үүрэг, зорилго, утга санааг ажиглавал:

1. Төгс ба төгс бус нэгжийн утга санааг илүү тодорхой болгож, өөрөөр тайлбарлан онцолж, давтаж хувиргах байдлаар хэрэглэдэг ёс байна. Жишээ нь: МУБИС нь багш мэргэжилтэн бэлтгэдэг, **өөрөөр хэлбэл**, сурган хүмүүжүүлэгчдийг бэлтгэдэг, **нөгөө үгээр** хэлбэл, бусад мэргэжлээр сургалт явуулдаг их сургууль юм. Үсэглэл, **өөрөөр хэлбэл**, цагаан толгойн ном хэвлэгдэв г.м.
2. Төгс ба төгс бус нэгжийн утга санааг илүү тодорхой болгож, өөрөөр хувирган хэлэх явцад утгыг дэлгэрүүлэх, зорилго, байдлаар хэрэглэдэг ёс байна. Жишээ нь: ...Асуудал ээдрээтэй бөгөөд онолын болон аргагүйн түвшинд хэлэлцэн шийдвэрлэх, ойлголтыг нэг мөр болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна. **Өөрөөр хэлбэл**, өнөөгийн манай судлаач шүүмжлэгчдийн дунд урлаг, уран зохиолын ангич, намч, ардач шинжийг нэг бол, бүрэн үгүйсгэх, эсвэл, уранзохиолын онолын судлагдахуунаас хасах, бүр эсвэл их, дээд сургуулийн мэргэжлийн ангийн сургалтаас чөлөөлөх гэсэн чиглэл байгаа юм. (С.Энхбаяр)
3. Дээрхийн эсрэг шинжтэй бөгөөд төгс ба төгс нэгжийн утга санааг уншигч ба сонсогчдод илүү хялбар ойлгомжтой болгох үүднээс өөрөөр хувирган тайлбарлах явцад утгыг хураах зорилготойгоор хэрэглэдэг ёс байна. Жишээ нь: Ийнхүү уранзохиолын нэг гол баатар чөргөр биш, намхан биетэй, шингэн хар халимагтай биш, халзан толгойтой, урт урт шар шүдтэй биш, жижигхэн цагаан шүдтэй болж "зүсээ хувилгасны" нууц учир тайлагдаж байгаа юм. **Өөрөөр хэлбэл**, Гаадамба гуайн нохойтдог зан нь хөдөлж, халимагтай баатраа халзан болгоод үсий нь хусчихсан хэрэг. (Д.Нямаа).
4. Төгс ба төгс бус нэгжийн утга санааг уншигч ба сонсогчдод илүү ойлгомжтой тодорхой болгох үүднээс өөрөөр хэлж, хувирган тайлбарлах явцад тодосгогч давхар гишүүний байдлаар хэрэглэдэг ёс байна. Жишээ нь: Монголчууд аливаа хүн, юмс, амьтдын нэрийг цээрлэн өөр үгээр орлуулахыгаа "илт өгүүлэх ёс" (онжад) гэнэ. **Өөрөөр хэлбэл**, ил тод хэлэх нэр, түүний цаана тусгай нэр нь нууцлагдсан байх ёс юм. (Л.Түдэв), Унаганы баярыг зуны туйлын дараа хийдэг. Гэхдээ унаганы баярын өдөр хэрэглэх уяаны багана, зэл татах уяа, шон тэргүүтэнг заавал нар буцахаас өмнө, **өөрөөр хэлбэл**, (6 дугаар сарын 22), зуны туйлаас өмнө босгож бэлтгэдэг. (Л.Түдэв) г.м.
5. Төгс ба төгс бус нэгжийн утга санааг уншигч ба сонсогчдод илүү ойлгомжтой тодорхой болгох үүднээс, нэг орон цагийн ойлголт ухагдахууныг нөгөө орон цагийн ойлголт ухагдахуунаар нь солин хувиргаж, өөрөөр хэлдэг ёс байна. Жишээ нь: Мацаг барих ёсон **буюу өөрөөр хэлбэл**, өнөөгийнхөөр махан хоолыг тэвчих буюу цагаан хоолоор солих ёсон (Л.Түдэв) г.м.
6. Төгс ба төгс бус нэгжийн утга санааг уншигч ба сонсогчдод илүү ойлгомжтой тодорхой болгох үүднээс, өөрөөр хэлж, хувирган нэгийг нь нөгөөтэй нь харьцуулах байдлаар

дэлгэрүүлж хэлдэг ёс байна. Жишээ нь: Д.Нямаагийн яруу найргийн онцлог нь энгийн бөгөөд даруухан шинжтэйд оршино. Эгэл даруухан гэдгийг би хамгийн эрхэм нандин утгаар нь, **өөрөөр хэлбэл**, онцгой содон харагдах гэж хичээдэггүй, гялгар мялгар чамин гоё үгээр уншигчдыг илбэдэх гэж сүржигнэгдэггүй гэсэн утгаар хэлж байгаа юм. (Ц.Хасбаатар) г.м.

7. Төгс ба төгс бус нэгжээр илэрхийлэгдэж буй хялбар бус утга санааг хялбаршуулах, эсвэл, хялбар энгүүн утга санааг хялбар бус, нарийн болгох үүднээс ондоогоор хэлж, тайлбарлан хувиргах тохиолдолд **"өөрөөр хэлбэл"**-ийг хэрэглэдэг ёс байна. Жишээ нь: Чимэг үг гэдэг нь жирийн нэг тодотголыг хэлдэг биш, харин хүний сэтгэлд юмны дүрийг тодорхой, амьд юм шиг тодруулж чадах тодотголыг хэлнэ. **Нөгөө үгээр хэлбэл**, уран тодотголыг хэлдэг. (Ц.Сүхбаатар).

Монгол ардын "Тааварчин гурав" гэдэг үлгэрт ганц үнээний хөхийг хөхөж амьдарсан гурван хүүгийн тухай өгүүлдэг. Тэгтэл нэг өдөр үнээ нь алга болчихжээ. Гурав хоноод тугал нь харангадаад үхчихэж. Гурвуул үнээгээ эрж явсаар, нэг ноёнд очиж гэнэ. Ноён, яагаад ч юм тэнсэх ч гэсэн юм уу тэдэнд үхрийн дал чанаж өгсөнд, Ах нь: "Энэ чинь манай мах байна гэж. Дунд хүү: -Үнээний мах байна гэж. Отгон хүү: -Манай болоод үнээний мах бол манай үнээний дал байна гэжээ. Ингэж тэд алдсан үнээгээ тэр хомхой ноёны идэш болсныг мэдэхэд чухамдаа дал тус болж байна. **Өөрөөр хэлбэл**, малын далны махаар шинжиж болдгийг өгүүлсэн байна. (Л.Түдэв) г.м.

8. Төгс ба төгс бус нэгжийн утга санааг уншигч ба сонсогчдод илүү тодорхой болгохын үүднээс өөрөөр хэлж тайлбарлан, хэлцээр орлуулан хавиргадаг ёс байна. Жишээ нь: Гэвч Лу багшийн эрдмийн аян нь эцэслэсэнгүй. Мэргэдийн номоор далай хийж, мэрийлт чармайлтаар онгоц хийж, нэгэн үзүүрт сэтгэлээр эрдэмд шамджээ. **Өөрөөр хэлбэл**, Шадавын хүү "Шамдавын лүү" болжээ. (Т.Галсан). Дүгэржав нь Ц.Дамдинсүрэн гуайд үнэхээр нэр хичээнгүй сайн туслагч болж, түүний далай мэт эрдмээс шамдан сурсан юм. **Өөрөөр хэлбэл**, энэ нь бух дагаж бяруу өвсөнд хүрдэг гэдгийн үлгэрийг үзүүлсэн юм. (Б.Бааст) г.м.

#### 4. Эцэст нь дүгнэж тэмдэглэхэд,

1. Монгол хэлний **"өөрөөр хэлбэл"** гэдэг нийлмэл бүтэцтэй холбох үг нь үндсэн үүргээрээ оруулан зэрэгцүүлэх холбоон дээр хэрэглэгдэж, төгс ба төгс бус хоёр нэгжийг холбодог задлаг хэрэглүүр юм.
2. **"Буюу"** гэдэг холбох үг нь гол төлөв зогсонги шинж чанартай нэр хэлхэцийг холбодог бол **"өөрөөр хэлбэл"** нь гол төлөв хөдлөнги шинж чанартай үйл хэлхэцийг холбодгоороо өвөрмөц ялгаатай юм.
3. **"Өөрөөр хэлбэл"** гэдэг хэрэглүүрээр монгол хэлний өгүүлбэр, цогцолбор, эхийн түвшинд тодотгогч-тодотгуулагчийн холбоо харьцаатай хоёр нэгжийг холбоход хэлэх өгүүлэхүйн талаасаа онцолбор илэрч, дэлгэрүүлсэн, хураасан, чухалчилсан, хялбаршуулсан, эс хялбаршуулсан г.м. гол төлөв өөр утгаар тайлбарласан шинжтэй нэгжүүд илэрч байна.
4. Монгол хэлний төгс ба төгс бус аль нэг нэгжийг нөгөөгөөр нь орлуулан сольж, тайлбарлаж онцлох нь холбосон орчинд шүтүүлж хийдэг өгүүлбэрзүйн түвшний параллел хувиргалтай ямар нэг талаараа холбоотой юм гэж үзэж болно.
5. Төгс ба төгс бус нэгжийг **"өөрөөр хэлбэл"**-ээр нөхцөлдүүлэн холбоход ойролцоо, эсрэг, төсөө утгат нэгжүүд үүсч, хувиргал явагддаг.
6. Монгол хэлний **"өөрөөр хэлбэл"** нь гол төлөв тайлбарламж, эргэцүүлэмж, хүүрнэмж, тоочимж эхийн уялдаа ярианд хэрэглэгдэж, орлосон нэгжийг холбодог өвөрмөц холбох үг мөн.

## Ном зүй

1. Б.Пүрэв-Очир, Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй, тэргүүн дэвтэр, нэмсэн II хэвлэл, Уб., 2001.
2. Б.Пүрэв-Очир, Монгол хэлний өгүүлбэрзүй, Утгасудлалын асуудлууд, дэд дэвтэр, нэмсэн II хэвлэл, Уб., 2000.
3. Б.Пүрэв-Очир, Монгол хэлний дадлагын өгүүлбэрзүй, (агуулга, аргазүй, дидактикийн асуудлууд), гутгаар дэвтэр, нэмсэн III хэвлэл, Уб., 2003.
4. Б.Пүрэв-Очир, Монгол хэлний "бол" холбоост нийлмэл өгүүлбэр, "Сурган хүмүүжүүлэгч" сэт., Уб., 1990, №3, 44-46-р тал.
5. Б.Пүрэв-Очир, Монгол хэлний "буюу" гэдэг холбох үгийн өгүүлбэрзүй-найруулгын үүрэг, "Шинжлэх ухааны Академийн мэдээ" сэт., Уб., 1993, №1, 13-17-р тал.
6. Б.Пүрэв-Очир, Монгол хэлний "харин" гэдэг холбох үгийн утга, үүрэг, найруулгад хийсэн зарим ажиглалт, Монголч эрдэмтний VI их хуралд зориулсан "Монгол хэлшинжлэл" цуврал, №1, (23), 6-р дэвтэр, Уб., 1992, 45-50-р тал.
7. Б.Пүрэв-Очир, Монгол хэлний зарим холбох үгийн утга, үүрэг, найруулгад хийсэн ажиглалт, Олон улсын монгол судлалын холбооны "MONGOLICA" цуврал, Уб., 1993, №4 (25), 55-74-р тал.
8. Ш.Лувсанвандан, Монгол хэлний хэлзүйн сурах бичиг, Үгүүлбэрийн зүй, дэд дэвтэр, Уб., 1956.
9. Ш.Лувсанвандан, Монгол хэлний үгүүлбэрзүйн асуудлууд, III боть, Уб., 2000, эмхтгэж өмнөтгөл хийсэн доктор Б.Пүрэв-Очир.
10. Ц.Өнөрбаян, Орчин цагийн монгол хэлний үгзүй, Уб., 1998.
11. Д.Отгонсүрэн, Монгол хэлний холбоос үгийн найруулгын үүрэг, товхимол, Уб., 1978.
12. Ю.Мөнх-Амгалан, Орчин цагийн монгол хэлний баймжийн ай, Уб., 1998.
13. А.Лувсандэндэв, "Ба"-гийн учир, Олон монгол хэл аялгууны харшуулсан хэл зүйн зарим асуудал, "Хэлбичгийн ухааны зарим асуудал", II, Уб., х.49-40.
14. Т.А.Бертагаев, Холбоос (Союзы) STUDIA MONGOLICA, Tomus-IV, Fasc. 1-7., Уб., 1968, др. А.Цог-Очирын орчуулга: МУБИС. Монгол судлалын сургууль, "Монгол хэлшинжлэл" цуврал (Эрдэм шинжилгээний сэтгүүл), №6, Уб., 2004, 205-236-р тал.

## ABSTRACT

### **The structure, meaning, function and usage of a connective word "in other words"/*өөрөөр хэлбэл*/ in Mongolian Language**

*B. Purev-Ochir (MSUE)*

Author studied in his academic article particular issues on structure, meaning, function, identity and various stylistic usage of a connective word "in other words" in modern Mongolian language.

Subject was studied and based on rich statements of exposition, cogitation, enumeration and narration and following several conclusions were drawn. They are:

1. A compound structured connective word "in other words" in Mongolian language is used on parenthical coordination and it is an analytic means which links perfect and imperfect units.
2. A connective word "or" mainly denotes nominal phrase that has stagnant property but "in other words"/*өөрөөр хэлбэл*/ links verbal phrase, which has unprogressive property.
3. When two units in determinative-determined relation are connected in syntactic, morphological and textual level, attribute is detected from speech aspect and mostly units that are explained in different meaning are detected such as extended, short, emphasized, unemphasised, unsimplified...etc.,
4. It can be considered, to replace and accent on explaining any perfect and imperfect units to each is associated with a dynamic conversion which is carried in related situation on syntactic level.
5. When perfect and imperfect units are connected with "in other words" similar , contrasted, paranomic meant units are derived and conversions are carried.
6. "In other words" in Mongolian language is a special connective word, which mainly used in contexts of exposition, cogitation, enumeration and links replaced elements.